



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТУЛШ АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/69/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2019 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл

Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Б.Эрдэнэзүл

Утас: 260512 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Их монгол хөлөг аудит”
ХХК

Утас: 99061771 Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хулээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын сурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
3.1	Балансын данстай холбоотой	9
3.1.1	Илрүүлэлт	9
3.1.2	Эрсдэл	9
3.1.3	Өгсөн зөвлөмж	9
3.1.4	Байгууллагаас ирсэн хариу тайлбар	9
3.2	Програм хангамжийн талаар	9
3.2.1	Илрүүлэлт	9
3.2.2	Эрсдэл	10
3.2.3	Өгсөн зөвлөмж	10
3.2.4	Байгууллагаас ирсэн хариу тайлбар	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийсэн зорилтот түвшин	15
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн таатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухайхууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.ГАНСҮХ ТАНАА

2019.03.25 № 06/594
таний -ны № -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлант материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерэнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ЫН 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж нь Нягтлан бodoх буртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бodoх буртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *З.Р.Р.*
Ц.НАРАНЧИМЭГ



Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2 Аудитын тайлан

2.1. Оршил

2018 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус үйлдвэрийн газрын захирал Г.Гансух Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад ирүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хан дуулахуйц запруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дунд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ихモンгол хөлөг Аудит ХХК нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлзээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшиний Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС, тэдгээрт нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль болон СТОУС, НББОУС, тэдгээрт нийцүүлэн баталсан аж, нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлдвэрийн газрын захиралд хүргүүлэхээр төлөвлөн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК-ийн аудитор Д.Буянравжих, аудиторын туслах Т.Оюун, Г.Бат-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НБОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангахад оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын удирдлага үйлдвэрийн газрын хувьд дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аudit

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдэж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Винница" програм хангамж ашигладаг байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн 7 асуудалд нарийчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөх баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бурд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материаллаг байдлын суурийг нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө, нийт орлогын дунгээс тооцоход өндөр байгаа тул нийт зардлын дунгээс тооцох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,010.4 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 10.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь материаллаг алдаа илүү давах магдлал бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг B201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг B401 маягаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрдэлт тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлхээд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн запруулгын талаарх мэдээллийг B30103 маягаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн запруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх запруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж ёгсөн	2	21.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	-	-	
	Дүн	2	21.8	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхан шатны баримтын бурдэл, их дүнтэй гэрээ хэлцлийг дахин үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 274 дүгээр тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 898.8 сая төгрөгийн орлогын, 361.5 сая төгрөгийн зардлын зорилтот түвшин батлагджээ. Батлагдсан зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тус байгууллагын орлогын төлөвлөгөө 237.4 хувиар давж, зарлагын төлөвлөгөө 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянах, баримтжуулсан болно.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшинд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, НБОУС, СТОУС, тэдгээрт нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайландаа тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүргээ хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайландаа шууд бөгөөд материалыг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой

3.1.1 Илрүүлэлт

Бэлэн мөнгөөр худалдан авсан 57 нэр төрлийн 21.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваадаа балтгэн нийлүүлэгч байгууллагын НӨАТ-ын баримтыг хавсаргаагүй, нийт 0.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваадаа орлогын баримт хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар сутгтан төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

3.1.2 Эрсдэл

Тушаал, зааврыг мөрдөөгүй байх, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Програм хангамжийн талаар

3.2.1 Илрүүлэлт

Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой ажил гүйлгээг Сангийн сайдын 2017 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу бүртгээгүй байна. Аудитын явцад програмтай холбоотой алдаа зөрчил гарч байгаа талаар эрх олгох байгууллагаас тодруулахад Ординат (САГ-2019/69/СТА-ТӨҮГ)

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

ХХК-ийн "Виницца" програм нь програмын тусгай зөвшөөрөл хүсэгчдийн жагсаалтад ороогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх, зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 5 дугаар бүлэгт "Дахин үнэлэгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл

Тушаал, зааврыг мөрдөөгүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.2.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018/1/1	2018/12/31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	61,013,131.89	1419,849,547.03
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	2,706,617.85	6,461,367.31
1.1.4	Бусад авлага	140,883.35	-
1.1.6	Бараа материал	115,211,992.45	131,092,213.79
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	2,997,992.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	179,072,625.54	1,560,401,120.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,407,504,936.85	13,060,454,103.04
1.2.2	Биет бус хөрөнгө	972,814,312.12	1,495,010,127.06
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,380,319,248.97	14,555,464,230.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,559,391,874.51	16,115,865,350.23
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	166,200.00	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	5,484,512.80	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.30	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,650,713.10	-
2.1.2	Үрт хугацаат өр төлбөр		-
	Үрт хугацаат өр төлбөрийн дүн		-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,650,713.10	-
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -терийн	14,869,843,049.32	15,362,339,049.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	44,414,440.00	282,110,305.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(360,516,327.91)	471,415,994.99
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,553,741,161.41	16,115,865,350.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,559,391,874.51	16,115,865,350.23

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлант

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	413,805,971.80	2,102,529,846.38
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	413,805,971.80	2,102,529,846.38
5	Хүүгийн орлого	1,869,068.31	23,824,637.49
8	Бусад орлого	56,686,504.15	6,908,180.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	592,485,677.40	1,006,804,174.15
11	Санхүүгийн зардал	3,771,923.75	3,636,363.64
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(178,684,191.29)	-
17	Бусад ашиг (алдагдал)		(178,607,591.39)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(302,580,248.18)	944,214,535.60
19	Орлогын татварын зардал	186,906.83	112,282,212.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(302,767,155.01)	831,932,322.90
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(302,767,155.01)	831,932,322.90

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хурийтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	11,276,843,049.32	-	(26,663,983.14)	11,250,179,066.18
Нягтлан бодох буртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(31,085,189.76)	(31,085,189.76)
Залруулсан үлдэгдэл	11,276,843,049.32	-	(26,663,983.14)	11,250,179,066.18
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	(302,767,155.01)	(302,767,155.01)
Өмчид гарсан өөрчлөлт	3,593,000,000.00	-		3,593,000,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	44,414,440.00		44,414,440.00
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	14,869,843,049.32	44,414,440.00	(360,516,327.91)	14,553,741,161.41
Залруулсан үлдэгдэл	14,869,843,049.32	44,414,440.00	(360,516,327.91)	14,553,741,161.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	831,932,322.90	831,932,322.90
Өмчид гарсан өөрчлөлт	492,496,000.00	-		492,496,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	237,695,865.92	-	237,695,865.92
2018 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	471,415,994.99	16,115,865,350.23

4.4 Аудит мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	469,059,441.00	2,320,616,040.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	456,268,969.00	2,315,498,281.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,790,472.00	5117,759.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	484,986,596.75	878,960,365.37
1.2.1	Ажиллагчдад төлсөн	198,268,632.00	192,825,370.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	54,677,555.00	54,439,017.11
1.2.3	Бараа материалы худалдан авахад төлсөн	11,820,598.00	72,041,558.00
1.2.4	Ашиглалтын зардалт төлсөн	48,159,041.00	45,622,427.50
1.2.5	Тулш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	24,670,198.00	24,031,467.00
1.2.6	Хүүгийн төлbert төлсөн	3,771,923.75	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	63,670,100.00	349,033,137.76
1.2.8	Даатгалын төлbert төлсөн	143,850.00	265,275.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	79,804,699.00	140,702,113.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,927,155.75)	1,441,655,674.63
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,869,068.31	23,417,502.51
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,869,068.31	23,417,502.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	52,280,000.00	106,236,762.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	52,280,000.00	57,236,762.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		49,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,410,931.69)	(82,819,259.49)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,000,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	40,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	55,647,850.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлbert төлсөн мөнгө	40,000,000.00	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	15,647,850.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,647,850.00)	-
4	Валютын ханшийн зөрүү		-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(81,985,937.44)	1,358,836,415.14
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний улдэгдэл	142,999,069.33	61,013,131.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн улдэгдэл	61,013,131.89	1,419,849,547.03

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн зорилтот түвшин

Үзүүлэлт	2018 оны		Зөрүү	
	Зорилт	Гүйцэтгэл	тоогоор	хувиар
Нийт орлого	898,800,000.00	2,133,262,664.60	1,234,462,664.60	237.3
Борлуулалтын орлого	673,200,000.00	665,970,778.00	(7,229,222.00)	98.9
Бусад орлого	216,000,000.00	1,436,559,068.20	1,220,559,068.20	665.1
Хүүгийн орлого	9,600,000.00	30,732,818.40	21,132,818.40	320.1
Нийт зардал	361,542,132.80	350,595,364.80	(10,946,768.00)	97.0
ББӨ				
Цалин	236,017,440.00	225,348,377.90	(10,669,062.10)	95.5
Нийгмийн даатгалын шимтгэл	28,322,092.80	30,181,743.00	1,859,650.20	106.6
Шуудан холбоо	6,120,000.00	2,329,203.60	(3,790,796.40)	38.1
Цахилгаан	65,082,600.00	45,789,805.00	(19,292,795.00)	70.4
Шатахуун			-	
Бичиг хэрэг			-	
Хог			-	
Хөдөлмөр хамгаалал			-	
Ашиглалтын зардал			-	
Засварын зардал	24,000,000.00	44,986,235.30	20,986,235.30	187.4
Бусад зардал			-	
Шагнал урамшуулал	2,000,000.00	1,960,000.00	(40,000.00)	98.0
Элэгдлийн зардал			-	
Халаалтын зардал			-	
Сэлбэг хэрэгсэл			-	
Сургалтын зардал			-	
Албан томилот			-	
Үйл ажиллагааны зардал			-	
Үйл ажиллагааны бус зардал			-	
Татвар төлөхийн өмнөх ашиг			-	
Орлогын татварын зардал			-	
Цэвэр ашиг			-	
Орлогын 1 төгрөгт ногдох зардал			-	
Нийт авлага			-	
Нийт өглөг			-	
Хөрөнгө худалдан авалт			-	

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/69/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж			Сая төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр	
1	2	3	4	5	
Балан менгеер худалдан авсан 57 нэр төрлийн 21.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод авахдаа бэлтгэн нийтийн байгууллагын НӨАТ-ын баримтыг хавсаргаагүй, нийт 0.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод авахдаа орлогын баримт хөтлөөгүй байна.	21.9	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Гансүх Б.Дэлгэрдалай	
Харенгийн дахин үнэлгээтэй холбоотой ажилтуйлжээг Сангийн сайдын 2017 дугаар тушаалаар батлагдсан арччилж болгоход бүртгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Гансүх Б.Дэлгэрдалай	

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс